



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 42 16, Факс: (976-51) 26 44 60,
Цахим шуудан: info@csc.gov.mn,
Цахим хуудас: www.csc.gov.mn

2026.06.29 № 01/1574
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих талаар Танаас ирүүлсэн асуултад Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу хариуг хүргүүлж байна.

Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих хяналтын хүрээнд 2024, 2025, 2026 он (06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар)-д нийт 1251 төрийн байгууллагын 15409 төрийн албан хаагчийг хамруулж хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүллээ. Хяналт шалгалтаар 998 томилгооны зөрчлийг илрүүлснээс 292 зөрчлийг томилох эрх бүхий албан тушаалтан хяналт, шалгалтын явцад арилгаж, 706 зөрчлийг арилгах арга хэмжээг Төрийн албаны Зөвлөл хэрэгжүүлснээр, биелэлт 94,7 хувьтай байна.

Төрийн албан хаагч нь өөрийн хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн талаар Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар шүүхэд гомдол нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас 2024, 2025, 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 99 иргэн, албан хаагчид холбогдох төрийн албан хаагчийг хууль бусаар албан тушаалаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг шүүхээр тогтоогдсон нийт 169 шүүхийн шийдвэрийг Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн байна. Шүүхийн шийдвэр гарсан 99 төрийн албан хаагчаас 59 нь төрийн захиргаа, 2 төрийн тусгай, 38 төрийн үйлчилгээний албан хаагч байна. Эдгээр шүүхийн шийдвэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү албан бичгийн нэгдүгээр хавсралтаар хүргүүлж байна.

Улсын Их Хурлаас 2002 оны 6 сарын 28-ны өдөр батлагдсан "Төрийн албаны тухай хууль"-ийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т "төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах;"-р заасан байсан. Таны албан бичигт дурдсан "сүүлийн 10 жилийн 2016, 2017, 2018 он" дээрх хуулиар зохицуулагдаж байсан бөгөөд энэ хугацаанд төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд

нэхэмжлэл гаргаж байсан баримт мэдээлэл байхгүй байна. Төрийн албаны тухай хууль 2017 онд шинэчлэгдэн батлагдсанаар дээр дурдсан 2002 оны хууль хүчингүй болсон.

Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Төрийн албаны тухай хууль 2019 оноос мөрдөгдөж эхлэхэд хуулийн 50.1 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасан байсан.

Төрийн албаны тухай хуульд 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдөр өөрчлөлт оруулж, уг зохицуулалтыг өргөжүүлэн “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж өөрчлөн найруулсан. Мөн хуулийн 50.2 дахь хэсэгт “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасан.

Төрийн албаны зөвлөл нь төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалд иргэнийг хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг зөвлөл болон шүүх тогтоосон тохиолдолд төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, биелэлтэд хяналт тавих чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс 2019-2026 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү албан бичгийн хоёрдугаар хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт ¹⁵ хуудастай.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН

Төрийн албаны зөвлөлийн 2026 оны
06 дугаар сарын 29-ний өдрийн 01/188
албан бичгийн нэгдүгээр хавсралт

Төрийн албаны зөвлөлд 2024, 2025, 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ирүүлсэн төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн талаарх шүүхийн шийдвэрийн судалгаа

Д/д	Шүүхийн нэр, огноо дугаар			Шийдвэрт хамаарах хариуцагч байгууллага
	Анхан	Давах	Хяналт	
1	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	2023.12.18 221/МА2023/0028	2024.03.15 28	Монгол Улсын Засгийн газар
2	Дархан-Уул аймаг дахь ЗХАШШ 2024.06.21 119/ШШ2024/0033	2024.09.24 221/МА2024/619	2025.05.26 001/ХТ2025/0049	Дархан-Уул аймаг дахь Шүүхийн Тамгын газар
3	Ховд аймаг дахь ЗХАШШ 2024.07.02 125/ШШ2024/0030	-	-	Ховд аймгийн Засаг дарга
4	Ховд аймаг дахь ЗХАШШ 2024.09.30 125/ШШ2024/0045	-	-	Ховд аймгийн ЗДТГ
5	Ховд аймаг дахь ЗХАШШ 2024.12.25 125/ШШ2025/0001	2025.03.27 221/МА2025/0220	2025.09.04 001/ШХТ2025/033 0	Ховд аймгийн ИТХ
6	Сүхбаатар дүүргийн ИХАШШ 2024.10.25 181/ШШ2024/04070	2024.12.23 210/МА2025/0001 4	-	Нийслэлийн Өргөө амаржих газар
7	Баянгол дүүргийн ИХАШШ	2023.12.22 210/МА2024/0001 2	-	Нийслэлийн ЕБ-ын 20 дугаар сургууль

	2023.10.16 102/ШШ2023/03705			
8	Сүхбаатар дүүргийн ИХАШШ 2023.12.25 181/ШШ2024/00036	2024.03.01 210/МА2024/0041 8	-	Монгол Улсын Боловсролын их сургууль
9	Сүхбаатар дүүргийн ИХАШШ 2023.12.26 182/ШШ2024/00043	2024.03.04 210/МА2024/0043 4	-	Монгол Улсын Далайн захиргаа ТБАГ
10	Баянзүрх дүүргийн ИХАШШ 2023.12.12 101/ШШ2023/05547	2024.03.11 210/МА2024/0048 2	-	Баянзүрх дүүргийн Засаг дарга
11	Сүхбаатар дүүргийн ИХАШШ 2024.01.12 181/ШШ2024/00168	2024.03.25 210/МА2024/0059 5	2024.06.04 001/ХТ2024/00123	Эрүүл мэндийн яам
12	Сүхбаатар дүүргийн ИХАШШ 2024.02.23 181/ШШ2024/00716	2024.04.24 210/МА2024/0086 1	-	Гаалийн ерөнхий газар
13	Баянзүрх дүүргийн ИХАШШ 2024.05.10 101/ШШ2024/02553	2024.07.19 210/МА2024/0142 6	-	Баянзүрх дүүргийн Засаг дарга
14	Сүхбаатар дүүргийн ИХАШШ 2024.09.27 181/ШШ2024/03588	2024.11.29 210/МА2024/0206 8	-	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв
15	Чингэлтэй дүүргийн ИХАШШ 2024.06.20 182/ШШ2024/02862	2024.09.11 210/МА2024/01738	-	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв

16	Баянгол дүүргийн ИХАШШ 2024.04.04. - 102/ШШ2024/01730	-	-	Нийслэлийн ЕБ-ын 146 дугаар сургууль
17	Баянгол дүүргийн ИХАШШ 2024.04.01 102/шш2024/01654	-	-	Баянгол дүүргийн Засаг дарга
18	Булган аймгийн СДИХАШШ 2024.08.12 132/ШШ2024/00329	2024.10.02 16	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа
19	Булган аймгийн СДИХАШШ 2024.04.05 №132/ШШ2024/001 47	-	-	Булган аймгийн Булган сумын ЕБ- ын 3 дугаар сургууль
20	Говь-Алтай аймгийн СДИХАШШ 2024.04.05 132/ШШ2024/00147 2024.09.27 133/ШШ2024/00400	2024.12.18 215/МА2024/0001 4	-	Говь-Алтай аймгийн Цогт сумын ЕБС
21	Говь-Алтай аймгийн СДИХАШШ 2024.12.04 133/ШШ2024/00510	-	-	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ЕБ- ын 4 сургууль

22	Дархан-Уул аймгийн СДИХАШШ 2024.05.16 00654	-	-	Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 17 цэцэрлэг
23	Дархан-Уул аймгийн СДИХАШШ 2024.06.10 00787	-	-	Дархан-Уул аймгийн ЕБ- ын Од цогцолбор сургууль
24	Өмнөговь аймгийн СДИХАШШ 2023.11.28 144/ШШ2023/00235	2024.02.16 203/МА2024/0000 6	-	Өмнөговь аймгийн Ханбогд сумын хорин есдүгээр цэцэрлэг
25	Сэлэнгэ аймгийн СДИХАШШ 2024.10.23 70	2024.04.09 208/МА2024/0002 3	2024.06.06 001/ШХТ2024/007 09	Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ЕБ- ын 2 дугаар сургууль
26	Сэлэнгэ аймгийн СДИХАШШ 2024.03.19 148/ШШ2024/00162	2024.05.13 208/МА2024/0003 2	2024.07.04 001/ШХТ2024/008 99	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг
27	Сэлэнгэ аймгийн СДИХАШШ 2024.10.08 148/ШШ2024/00489	2024.12.04 208/МА2024/0006 9	-	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг
28	Сэлэнгэ аймгийн СДИХАШШ 2024.12.18 148/ШШ2024/00659	2025.02.12 208/МА2025/0001 0	-	Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ЕБ- ын 2 дугаар сургууль

29	Хэнтий аймгийн СДИХАШШ 2024.05.28 157/2024/000/99	2024.09.17 226/МА2024/0001 6	2024.12.03 1492	Хэнтий аймаг дахь Шүүхийн тамгын газар
30	Завхан аймгийн СДИХАШШ 2024.04.19	-	-	Завхан аймгийн Их- Уул сумын нэгдсэн эмнэлэг
31	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2024.12.06 128/ШШ2025/1014	2025.02.25 221/МА2025/0147	2025.05.12 001/ШХТ2025/023 0	УИХ-ын Тамгын газар
32	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2024.12.16 128/ШШ2025/1034	2025.01.23 221/МА2025/0061	2025.03.11 001/ШХТ2025/011 7	Нийслэлийн Байгаль орчны газар
33	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.01.07 128/ШШ2025/0031	-	-	Боловсролы н яам
34	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.01.28 128/ШШ2025/0095	2025.06.05 221/МА2025/0379	-	Нийслэлийн Замын хөгжлийн газар
35	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.05.13 128/ШШ2025/0347	2025.07.09 221/МА2025/0490	2025.09.30 001/ШХТ2025/041 6	Улсын бүртгэлийн ерөнхий газар
36	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.05.16 128/ШШ2025/0370	-	-	Хөдөлмөр, халамж үйлчилгээни й ерөнхий газар
37	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.09.10 128/ШШ2025/0621	-	-	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

38	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.09.08 128/ШШ2025/0607	2025.12.02 221/МА2025/0753	-	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
39	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.09.30 128/ШШ2025/0663	2025.11.05 221/МА2025/0699	2025.12.25 001/ШХТ2026/000 4	Нийслэлийн Замын хөгжлийн газар
40	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.10.20 128/ШШ2025/0724	-	-	Шүүхийн ерөнхий зөвлөл
41	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.12.16 128/ШШ2025/0959	-	-	Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын ерөнхий газар
42	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.02.26 128/ШШ2025/0174	2025.05.22 221/МА2025/0340	2025.10.03 001/ХТ2025/0082	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
43	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.03.26 128/ШШ2025/0215	-	-	Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
44	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.03.31 128/ШШ2025/0227	2025.06.05 221/МА2025/0383	2025.09.19 001/ШХТ2025/036 6	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
45	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.04.04 128/ШШ2025/0236	2025.05.29 221/МА2025/0356	2025.09.19 001/ШХТ2025/036 8	Нийслэлийн бизнес инновацийн газар
46	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.04.10 128/ШШ2025/0256	-	-	Соёл спорт аялал жуулчлал

				залуучуудын яам
47	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.04.24 128/ШШ2025/0292	-	-	Биеийн тамир, спортын Улсын хороо
48	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.05.06 128/ШШ2025/0314	2025.08.13 221/МА2025/0523	-	Нийслэлийн Боловсролын газар
49	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.05.06 128/ШШ2025/0315	-	-	Хууль Зүйн дотоод хэргийн яам
50	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ДИХАШТШ 2025.11.25 191/ШШ2025/10552	-	-	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар
51	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ДИХАШТШ 2025.10.31 191/ШШ2025/09362	-	-	Боловсролын яам
52	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ДИХАШТШ 2025.04.23 191/ШШ2025/03428	2025.06.13 210/МА2025/0103 1	-	Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв
53	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ДИХАШТШ 2025.03.26 191/ШШ2025/02538	2025.05.16 210/МА2025/0080 8	2025.09.09 001/ШХТ2025/007 56	"Нийслэлийн болговсролын газар"

54	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ДИХАШТШ 2025.06.10 191/ШШ2025/05308	2025.09.08 210/МА2025/0152 9	2025.12.02 001/ШХТ2025/011 49	Нийслэлийн 61-р цэцэрлэг
55	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан ДИХАШТШ 2025.01.09 192/ШШ2025/00059	-	-	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв
56	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн ХААШТШ 2025.04.22 197/ШШ2025/04894	2025.05.26 210/МА2025/0090 5	-	Баянгол дүүргийн насан туршийн суралцахуй н төв
57	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн ХААШТШ 2025.10.01 197/ШШ2025/12475	-	-	Биеийн тамир, Спортын улсын хороо
58	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн ХААШТШ 2025.11.03 197/ШШ2025/14831	-	-	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
59	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн ХААШТШ 2025.11.14 197/ШШ2025/15827	-	-	Улсын филармони
60	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн ХААШТШ 2025.11.20 197/ШШ2025/16317	-	-	Хөдөлмөр халамж, үйлчилгээни й ерөнхий газар

61	Багануур дүүргийн ИХАШШ 2025.01.14 103/ШШ2025/00051	2025.03.10 210/МА2025/0044 6	2025.05.29 001/ШХТ2025/005 58	Нийслэлийн 131 дүгээр цэцэрлэг
62	Нийслэл дэх Захиргааны ХАШШ 2025.08.11 128/ШШ2025/0546	2025.10.01 221/МА2025/0629	2025.11.25 001/ШХТ2025/053 2	Татварын Ерөнхий газар
62	Архангай аймгийн СДИХАШШ 2025.04.16 301/ШШ2025/00188	-	-	Архангай аймгийн Тариат сумын Хүүхдийн цэцэрлэг
64	Баян-Өлгий аймгийн СДИХАШШ 2025.03.14 302/ШШ2025/00221	-	-	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын ЕБС
65	Баян-Өлгий аймгийн СДИХАШШ 2025.05.16 302/ШШ2025/00441	-	-	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ЕБС
66	Булган аймгийн СДИХАШШ 2025.09.09 304/ШШ2025/00532	-	-	Булган аймгийн ЗДТГ
67	Булган аймгийн СДИХАШШ 2025.09.08 304/ШШ2025/00531	2025.12.19 214/МА2025/00016	-	Булган аймгийн Булган сумын ЕБС- 3
68	Говь-Алтай аймаг дахь ЗХАШШ 2025.04.01 112/ШШ2025/0013	-	-	Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг дарга

69	Говь-Алтай аймгийн СДИХАШШ 2025.07.24 305/ШШ2025/00474	-	-	Говь-Алтай аймгийн Худалдан авах ажиллагаан ы газар
70	Говь-Алтай аймгийн СДИХАШШ 2025.08.01 305/ШШ2025/00492	-	-	Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Соёлын төв
71	Говь-Алтай аймгийн СДИХАШШ 2025.09.30 305/ШШ2025/00644	-	-	Говь-Алтай аймгийн Цогт сумын Соёлын төв
72	Говь-Алтай аймгийн СДИХАШШ 2025.12.10 305/ШШ2025/00877	-	-	Говь-Алтай аймгийн Төрийн архивын хэлтэс
73	Говь-Алтай аймгийн СДИХАШШ 2024.12.04 133/ШШ2024/00510	2025.02.07 215/МА2025/00004	-	Говь-Алтай аймгийн ЕБ- ын 4 дүгээр сургууль
74	Дорноговь аймаг дахь ЗХАШШ 2025.08.26 115/ШШ2025/0018	-	-	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ
75	Дорнод аймгийн СДИХАШШ 2025.11.11 309/ШШ2025/1286	-	-	Дорнод аймгийн ИТХ
76	Дундговь аймгийн СДИХАШШ 2025.12.01 170/ШШ2025/00723	-	-	Дундговь аймгийн Сайнцагаан

				сумын 1-р цэцэрлэг
77	Завхан аймгийн СДИХАШШ 2025.02.13 311/ШШ2025/00064	2025.03.26 205/МА2025/00005	-	Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж
78	Завхан аймгийн СДИХАШШ 2025.08.01 311/ШШ2025/00377	-	-	Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж
79	Завхан аймгийн СДИХАШШ 2025.07.02 311/ШШ2025/00303	-	-	Завхан аймгийн Боловсролы н газар
80	Өвөрхангай аймаг дахь ЗХАШШ 2025.02.17 121/ШШ2025/0002	-	-	Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс
81	Өмнөговь аймгийн СДИХАШШ 2025.10.21 313/ШШ2025/00560	-	-	Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээни й төв
82	Сэлэнгэ аймгийн СДИХАШШ 2025.11.24 316/ШШ2025/00107 3	-	-	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг
83	Сэлэнгэ аймгийн СДИХАШШ 2025.09.25 316/ШШ2025/00800	-	-	Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ИТХ
84	Увс аймгийн СДИХАШШ	-	-	Увс аймгийн Завхан сумын ЭМТ

	2025.11.20 318/ШШ2025/01037			
85	Увс аймгийн СДИХАШШ 2025.01.23 318/ШШ2025/00053	2025.11.28 318/ШШ2025/010 85	-	Увс аймгийн Засаг дарга
86	Хөвсгөл аймаг дахь ЗХАШШ 2025.01.20 126/ШШ2025/0002	2025.04.17 221/МА2025/0268	-	Хөвсгөл аймгийн Засаг дарга
87	Хэнтий аймгийн СДИХАШШ 2025.05.16 321/ШШ2025/00285	-	-	Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг
88	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь СДШ 2025.11.27 141/ШШ2025/00309	-	-	Завхан аймгийн Тосонцэнгэ л суман дахь МБС
89	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь СДШ 2025.05.29 149/ШШ2025/00256	-	-	Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЗДТГ
90	Архангай аймаг дахь ЗХАШШ 2025.03.27 109/ШШ2025/0010	2025.06.04 221/МА2025/0370	-	Архангай аймгийн ГХБХБГ
91	Дархан-Уул аймаг дахь ЗХАШШ 2025.05.27 114/ШШ2025/0022	2025.07.31 221/МА2025/0509	-	Дархан-Уул аймаг дахь Шүүхийн тамгын газар
92	Баян-Өлгий аймаг дахь ЗХАШШ 2025.06.12 110/ШШ2025/0052	2025.09.03 221/МА2025/0567	-	Баян-Өлгий аймгийн Засаг дарга

93	Ховд аймаг дахь ЗХАШШ 2025.06.26 49	2025.09.04 221/МА2025/0572	-	Ховд аймгийн Боловсролы н газар
94	Нийслэл дэх ЗХАШШ 2025.06.18 0468	2025.10.07 221/МА2025/0649	2026.01.27 001/ХТ2026/0012	Улсын бүртгэлийн ерөнхий газар
95	Ховд аймаг дахь ЗХАШШ 2025.08.29 125/ШШ2025/0059	2025.10.28 221/МА2025/0688	-	Ховд аймгийн Боловсролы н газар
96	Нийслэл дэх ЗХАШШ 2025.08.28 128/ШШ2025/0586	2025.11.03 221/МА2025/0704	2026.01.13 001/ХТ2026/0009	Цагдаагийн ерөнхий газар
97	Ховд аймаг дахь ЗХАШШ 2025.09.25 125/ШШ2025/0063	2025.11.20 221/МА2025/0738	-	Ховд аймгийн Эрүүл мэндийн газар
98	Нийслэл дэх ЗХАШШ 2025.09.16 128/ШШ2025/00633	2025.12.18 221/МА2025/0796	2026.02.12 001/ШХТ2026/006 7	Улсын бүртгэлийн ерөнхий газар
99	Увс аймаг дахь ЗХАШШ 2025.04.17 124/ШШ2025/0015	-	-	Увс аймгийн ИТХ

--ooOoo--

**Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн
50.1, 50.2 дахь хэсгийг хэрэглэсэн талаарх мэдээлэл**

1.Төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх мэдэгдэл хүргүүлсэн тухайд:

Давхардсан тоогоор нийт 5,651.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий 395 мэдэгдлийг буруутай шийдвэр гаргасан иргэн, албан тушаалтанд хүргүүлснээс 54 иргэн, албан тушаалтан 562.8 сая төгрөгийг шүүхэд хандахгүйгээр мэдэгдлийн дагуу нөхөн төлсөн.

Д/д	Он	Мэдэгдлийн тоо	Мэдэгдлийн дүн	Мэдэгдлийн дагуу төлсөн тоо	Мэдэгдлийн дагуу төлсөн дүн
1	2019	2	9,680,501	-	-
2	2020	4	44,782,229	1	4,496,732
3	2021	15	159,289,987	1	2,055,699
4	2022	18	185,771,742	4	63,196,373
5	2023	141	1,505,638,286	6	51,763,638
6	2024	121	2,037,593,321	29	302,150,289
7	2025	59	1,059,117,072	8	77,791,055
8	2026	35	649,941,421	5	61,385,235
Нийт		395	5,651,814,559	54	562,839,021

2.Иргэний болон захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан тухайд:

Төрийн албаны зөвлөлөөс иргэний болон захиргааны хэргийн шүүхэд давхардсан тоогоор 287 иргэн, албан тушаалтанд холбогдох 4,922.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий 287 нэхэмжлэлийг тус тус гаргасан.

Д/д	Он	Нэхэмжлэл		Шүүхээс шийдвэрлэсэн нэхэмжлэл		
		тоо	дүн	тоо	Нэхэмжлэл гаргасан дүн	Шийдвэрлэсэн дүн
1	2019	2	9,680,501	-	-	-
2	2020	3	37,917,618	-	-	-
3	2021	13	140,875,110	6	45,449,652	16,539,931
4	2022	10	53,381,281	12	159,568,640	153,934,447
5	2023	95	1,178,815,655	32	345,926,951	291,536,200
6	2024	79	1,735,734,112	55	772,274,031	433,131,938
7	2025	58	1,299,473,511	40	633,241,529	333,210,725
8	2026	27	466,527,347	26	1,046,097,817	296,381,415
Нийт		287	4,922,405,135	171	3,002,558,620	1,524,734,656

3.Төрд учруулсан хохирлыг буруутай иргэн, албан тушаалтнаар төлүүлж төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн тухайд:

2019-2025 он, 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар мэдэгдэл болон шүүхийн шийдвэрээр нийт 240 иргэн, албан тушаалтнаас 1,667.1 сая төгрөгийг төрийн санд нөхөн төвлөрүүлж, төрийг хохиролгүй болголоо.

Д/д	Он	Төлбөр төлсөн иргэн, албан тушаалтан	
		Тоо	Дүн
1	2019	-	-
2	2020	1	4,496,732
3	2021	2	4,277,429
4	2022	8	39,833,803
5	2023	38	253,679,038
6	2024	83	623,356,514
7	2025	71	478,209,847
8	2026	37	263,304,404
Нийт		240	1,667,157,767